



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/168

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.3.2 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар өмчлөх эрхээсээ татгалзаж орон сууцны зориулалтаар газар эзэмших хүсэлт гаргасан дээрх аж ахуй нэгжид эзэмшүүлсүгэй.


а. Жаргалант сумын Буянт багийн Цэцэрлэгт хүрээлэн 1 дүгээр гудамжны 164 тоотод байрлах, 906.0 метр квадрат газрыг “Дарви өргөө” ХХК /5352606/-д орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар,

б. Жаргалант сумын Буянт багийн Цэцэрлэгт хүрээлэн 1 дүгээр гудамжны 160 тоотод байрлах, 767.0 метр квадрат газрыг “Дарви өргөө” ХХК /5352606/-д орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар

в. Жаргалант сумын Буянт багийн Жаргалант хайрхан 1 дүгээр гудамжны 124 тоотод байрлах, 547.0 метр квадрат газрыг “Ховд Сити такси” ХХК /4080262/-д орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ